



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/93

Хажуу шинэ үс

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалт, Мал, амьтны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 22-4096 дугаартай шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын 1 дугаар багийн нутаг "Элгэн" хэмээх газарт нутаглаж буй малчны суурьт бог малын мялзан өвчин гарсантай холбогдуулан нийт малчид мал бүхий иргэдэд урьдчилан сэргийлж анхааруулан голомтын бүсэд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн голомтын газраас 5км-т хорио цээрийн дэглэм тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч нийт малчдад зарлан мэдээлэхийг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Мөнхтөгөлдөр)-д, малд үзлэг хийж халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж), Угтаал чандмань хоршоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын их эмч (Д.Амгалан) нарт тус тус даалгасугай.

3. Хүн малын шилжилт хөдөлгөөн харуул хяналтын постыг 24 цагаар ажиллуулан, хяналт тавин ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл), Хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201293